



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 0103

Дархан

Г Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд Г
өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3 дахь хэсэг, "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн албан хаагчдын хөдөлгөөн, өөрчлөлттэй холбогдуулан Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Дарга:	Т.Наранчимэг	(Хөдөө аж ахуйн цаг уурын мэргэжилтэн)
Гишүүд:	Ш.Цагаанцоож	(Уур амьсгалын технологич инженер)
	Ш.Батчимэг	(Ерөнхий нягтлан бодогч)
	Э.Эрдэнэтөгс	(Шаазгайт өртөөний мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Ц.Алтангэрэл	(Урьдчилан мэдээлэхийн инженер)

2. Ёс зүйн дэд хороонд доорх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.

2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгох;

2.2 Албан хаагчийн нууцыг хадгалж, шударга байдлыг эрхэмлэн ажиллах;

2.3 Соён гэгээрүүлэх, мэдээлэл түгээх, сургалт хийх ажлыг зохион байгуулах;

2.4 Үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг хангах;

2.5 Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн мэдээллийг тухай бүрд нь төвийн сайтад байршуулах;

2.6 Ёс зүйн дэд хорооны ажлын тайлан мэдээг хууль, тогтоомжийн дагуу холбогдох байгууллага, даргын зөвлөлд тайлагнах;

3. Ёс зүйн дэд хорооны ажлын үнэлгээнд суурилсан урамшуулал олгох асуудлыг журмын дагуу шийдвэрлэнэ.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан төвийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



С.АЛТАНДОЛГИОН